

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2017.04.25-2017.05.25/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба улирал бүр хийсэн ажлын тайлангаа иргэдэдээ танилцуулж байхаар төлөвлөн ажиллаж байна. 2017 оны 1-р улиралд хийсэн ажлын тайлангаа өнгөрөгч сарын 28-ны өдөр сумын соёлын төвд зохион байгуулсан байна. Уг уулзалтаар сумын ИТХ-ын дарга Ц.Эрдэнэбат хийсэн ажлын тайлангаа танилцуулж тэдний санал хүсэлтийг хүлээн авч харилцан ярилцсан уулзалт боллоо.



Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 12-р хуралдаан 2017.05.11-ний өдөр, 13-р хуралдаан 2017.05.23-ны өдөр боллоо. ИТХ-ын Тэргүүлэгчдийн 13-р хуралдаанаар:

1. Сумын 2017 оны төсвийн тодотгол
2. Сумын 2017 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө
3. Төлөөлөгч Ц.Даваасүрэнгийн 2017.05.19-ны өдрийн №01 тоот албан бичиг
4. ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017.05.11-ны өдрийн №32 тоот тогтоолд өөрчлөлт оруулах тухай гэсэн эдгээр асуудлыг хэлэлцлээ.



Аймгийн Төрийн сангийн хэлтсийн харъяа байгууллагуудын Нээлттэй хаалганы өдөр 2017 оны 05-р сарын 10-ны өдөр суманд зохион байгуулагдаж иргэдэд үйлчилсэн.



Аймгийн Засаг даргын нэрэмжит Спортын бага наадамд спортын 8 төрлөөр сумын баг тамирчдыг бэлтгэн оролцууллаа.



ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2017 оны 4-р сарын 30 -ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	13 219 000	13 138 270
2.	ЗДТГ	100 577 391	100 048 805

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /төгрөгөөр/	Зардлын гүйцэтгэл /төгрөгөөр/
1.	Эрүүл мэндийн төв	97 970 500	95 499 778
2.	Соёлын төв	21 020 500	20 206 895
3.	3-р сургууль	329 794 000	282 391 998
4.	3-р цэцэрлэг	145 965 200	127 847 915

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

3-Р СУРГУУЛЬ :

2016-2017 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэн орсон сурагчид минь уншиж, бичиж сурсныхаа “Эрдмийн баяр”-аа тэмдэглэж сурч мэдсэн зүйлээ эцэг эх, багш найз нөхөд сургуулийн удирдлагуудад тайлагналаа. Эрдмийн баярт нийт 77 сурагч хамрагдаж 100% уншиж бичиж бодож сурсан амжилттайгаар эрдмийн гараагаа эхэллээ.



Говьсүмбэр аймгийн хэмжээнд сурагчдын анги хэлний мэдлэгийн түвшинг ахиулах зорилгоор зохион байгуулагддаг Англи үг үсэглэх буюу **Spelling bee** тэмцээнд, Аймгийн засаг даргын нэрэмжит математикийн олимпиад, “Эх хэл эрдмийн түлхүүр” монгол хэлний олимпиадуудад амжилттай оролцсон.

Эко клубээс "Шивээговь сумын хөгжлийн төлөө хамтдаа" сэдэвтэй илтгэлийн уралдаан, "Миний мөрөөдлийн Шивээговь" сэдэвтэй гар зургийн уралдаандуудыг тус тус зохион байгуулж амжилттай оролцсон сурагчдыг урамшууллаа.



Зэвсэгт хүчний 96 жил, Монгол хүн сансарт ниссэний 36 жилийн ой, “Батлан хамгаалахын эрх зүйн шинэчлэл”-ийг эрчимжүүлэх аяны хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Цэргийн штаб, Боловсрол Соёл, Урлагийн газар, Улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн аймаг дахь салбар хамтран зохион байгуулсан “Би ирээдүйн офицер” тэмцээнд 3-р сургуулийн “Энхийн манаа” баг хүрэл медаль хүртэж амжилттай оролцлоо.



Боржигин морин хуурын сургалт 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн хичээллэж байна. Сургалтанд 22 сурагч хамрагдаж байна.



2017 оны 05 сарын 05 нд 2016-2017 оны хичээлийн жилийн сургуулийн үйл ажиллагааг эцэг, эх олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор “Номын гэгээ тайлант өдөрлөг”, “Авьяас цэцэглэх өдөрлөг” тайлант өдөрлөгийг зохион байгууллаа. Уг үйл ажиллагаагаар сурагчдын урлагийн тоглолт, сонгон дугуйлан секцийн үйл ажиллагааг сурталчилсан багш, сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, “Ном” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан тэмцээн уралдааны тэргүүн байранд орсон сурагчдын шилдэг номер зэргийг үзүүлсэн арга хэмжээ боллоо. Үүнд давхардсан тоогоор 100 гаруй эцэг эхчүүдэд үйл ажиллагаагаа сурталчилан таниуллаа.



3-р ахлах сургуулийн 2016-2017 оны төгсөгчдийн 27 дахь удаагийн “Мөнгөн хонхны” баяр 2017 оны 05 сарын 12-ны өдөр зохион байгуулагдлаа. Сумын удирдлагууд болон багш, сурган хүмүүжүүлэгчид нь сурлага, урлаг, спортын амжилтаараа манлайлан суралцсан сурагчдыг “Сумын Шилдэг сурагч”, “Эрдэм”, “Авъяас” алтан медаль, “Тэргүүний тамирчин”, “Тэргүүний сурагч” медалиар энгэрийг нь мялаалаа.



3-Р ЦЭЦЭРЛЭГ

Хөгжмийн сайн үйл ажиллагаанд Ахлах, Бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг бэлтгэн оролцуулж, бусад цэцэрлэгийн багш нарт хүүхэд нэг бүрийг хөгжмийн үйл ажиллагаагаар хөгжүүлж буй туршлагаас хуваалцлаа.



Хүүхдүүдийн дунд хаврын гоёл “Загварын ШОУ-2017” уралдааныг зохион байгуулж, 9 бүлгийн 89 хүүхэд оролцлоо



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:

5 сарын 5-нд “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн нээлтийг зохион байгуулж, хүрэлцэн ирсэн 40-65 насны 57 иргэд сургалт зохион байгуулсан



05 сарын 12-ны өдөр ГСА-ын Сүрьеэгийн тасгийн сувилагч нартай хамтран Цэцэрлэгийн насны 138 хүүхдэд Сүрьеэ өвчнийг илрүүлэх Мантуугийн сорилыг тавьж ажилласан.



НИЙГМИЙН БОДЛОГО

Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд витаминжуулах шаардлагатай байнгын асаргааны иргэдийн дархлааг дэмжих, асарч буй иргэдэд сургалт, зөвлөгөө өгөх ажлыг хийж гүйцэтгэв.

Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Аз жаргалтай гэр бүл” аяныг зохион байгууллаа. Тус аяны хүрээнд сумын Хамтарсан багийн зорилго, үйл ажиллагаа, МУ-ын Гэр бүлийн хүчихийлэлтэй тэмцэх тухай хуулийг иргэдэд таниулан сурталчлах ажлууд болон гэр бүл судлаач РН,Д Б.Оюун-Эрдэнэтэй хамтран сумын 95 иргэнд “Гэр бүлийн үнэ цэнэ” лекцийг зохион байгуулж ажилласан.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Сумын Засаг даргын 2017 оны 3-р сарын 07-ны өдрийн А/15 тоот захирамжаар Зорилтот өрх бүрт нийгмийн үйлчилгээг цогцоор нь хүргэх, хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний

хөтөлбөрт хамрагдах 1, 2-р багийн 16 өрхийг сонгож ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 03-р сарын 18-ны өдрийн тоот тогтоолоор баталгаажуулан аймгийн ХХҮГ-т хүргүүлсэн. Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдсан 16 өрхөд чиглэсэн өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах сургалтыг 2017 оны 05-р сарын 16-ны өдөр зохион байгуулан судалгааны дагуу сумын 2017 оны өрхийн хөгжлийн төлөвлөгөөг гаргаад байна.

УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 52 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 11 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

2017 оны 5 сарын 22-ны байдлаар газраа анх удаа өмчилж авч байгаа 8 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн 63 гэрчилгээг эздэд нь олгоод байна. Нийт 8 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аймаг орохгүйгээр сумаасаа авч хэвшээд байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль болохтой холбогдуулан хаягийн зөрчлийг арилгах аянг үргэлжлүүлэн зарлаад байна. Уг аяны хүрээнд хаягийн давхардалтыг арилгах, орон нутагт шилжүүлэггүй хөдөлмөр эрхэлж буй иргэдийн судалгааг гаргаж орон нутгийн шилжүүлэгийг хийлгэх, мөн шинээр иргэний үнэмлэх авч байгаа болон 25, 45 насны сунгалтаа хийлгээгүй иргэдийн судалгааг гаргаж үнэмлэх захиалах ажлыг хийж гүйцэтгэж байна. Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2017 ОНЫ 05 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	27				27	16	11
Төрсөн эх	2	27				27	-	27
Бүртгүүлсэн гэр бүл	3	6				6	6	6
Нас баралт	4	8				8	6	2
Цуцалсан гэр бүл	5	2				2	2	2
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	46				46	42	20
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	50				50	20	30

СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2017 оны 5-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Эцэг тогтоолт	2500	3	7500				
2	Орлогын өсөлтөөс үүдэн аажимд ааааёо	5000	3	15000				
3	Гэрлэлт цуцлалт	2500	2	5000				
4	Гэрлэлт	2500	3	7500				
5	Иргэний үнэмлэхний үнэ	15000	19	285000	3300	19	62700	
ДҮН		320000			62700			
НИЙТ ДҮН		382700						

БАЙГАЛЬ ОРЧИН

Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах хуваарийн дагуу 2017.05.17-ний өдөр зохион байгуулж, цэвэрлэгээнд 15 аж ахуйн нэгж, албан байгууллага, 173 хүн хамрагдаж 21,3 м куб хог хаягдал цэвэрлэсэн.



Сумын хэмжээнд бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан мод тариа ажлыг зохион байгууллаа. Мод тарих ажилд 11 байгууллага, аж ахуйн нэгж оролцож 313 мод бут тарьсан.



Булаг уст цэгийг цэвэрлэх ажлыг 2017.05.18-ний өдөр зохион байгуулж явуулсан. Цэвэрлэх ажилд 7-н албан байгууллага, 103-н иргэн хамрагдаж Нэртийн булаг, Бэхтийн булгуудыг цэвэрлэж 12 м куб ахуйн хог хаягдлыг ачиж зайлуулсан.





Ой хээрийн түймэр, Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2-р багийг Засаг даргатай хамтран Урсахын ухаа, Нүхэн сондуул, Бэлхийн улаан өндөр зэрэг газруудаар эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулж явуулсан. Эргүүл шалгалтаар 6-н малчин өрхүүдтэй уулзаж Амьтны тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийг тайлбарлаж, Ой хээрийн түймрээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөмж тараасан.



Сумын албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн тохижилтын ажлын төлөвлөгөөг нэгтгэн гаргаж гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан.





МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ

Мал төллөлт төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээ

	Мөрийн дугаар	Бүгд	ҮҮНЭЭС				
		1	2	3	4	5	6
			Ингэ	Гүү	Үнээ	Эм Хонь	Эм Ямаа
Төллөсөн хээлтэгч	01	16691	26	361	446	8280	7578
Гарсан төл	02	16758	26	361	446	8315	7610
Хорогдсон төл	03	13	0	0	0	9	4
Бойжсон төл	04	16745	26	361	446	8306	7606

	Мөрийн дугаар	Бүгд	ҮҮНЭЭС				
		1	2	3	4	5	6
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал, бүгд	01	77			11	38	28
Үүнээс: Өвчинөөр хорогдсон	02	2			2		
Хорогдсон хээлтэгч	03	21			2	9	10


Нийт 19113 мал төллөхөөс одоогийн байдлаар 16691 толгой мал төллөлж мал төллөлт 87%-тай байна.

Сумын Засаг даргын А/29 дугаар “Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх тухай” захирамжийн дагуу 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарилгын ажил эхлэж нийт 1605 толгой үхэр хамрагдахаас одоогийн байдлаар 51 өрхийн 1281 толгой үхэр, 2 өрхийн 13 толгой гахай хамрагдсан.

ЗДТГ-ын эзэмшлийн 12 га газарт төмс, хүнсний ногоо тарих хүсэлтэй иргэдийн өргөдлийг хүлээн авч, газрыг хуваарилан өгч гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.



Аймгийн ХХААГ-тай хамтран газар тариалангийн технологийн сургалтыг нийт 16 иргэнд зохион байгуулж, арга зүйн заавар зөвлөмжийг өгч ажилласан.



Аймгийн ХХААГ-ын удирдлагууд тасгийн болон сумын жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарын үйл ажиллагаатай танилцаж, заавар зөвлөмжийг өгч ажилласан.



Хаврын бэлчээрийн даац, багтаамж тооцох судалгааг 4 цэгээс тус бүр дээж авч тооцоолоход 0,82 цн/га дундаж ургацтай байна. Бэлчээрийн хортон мэрэгчийн тандалт судалгааг 3 цэгт тус бүр 25х25 м талбайд тооцоолоход үлийн цагаан оготны тархалт хэвийн хэмжээнд байна.



103 толгой бог мал хээлтүүлэгчид хаврын хянан баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.



Хаврын тариалалтын ажлыг эхлүүлж төмс 1 га, манжин 0,4 га, лууван 0,3 га, тарвас 2,6 га, чацаргана 0,024 га талбайд тариалаад байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН

2017 оны ОНХС-ийн 1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа, хамгаалалтын ажлыг 1-р багийн Э. Оюунбилэгтэй гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлж байна.



ОНХС-ийн 12,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Ахуйн хог хаягдал тээвэрлэх ажил”-ын гүйцэтгэгчээр Илчлэг шивээ ОНӨҮГазар шалгаран гэрээ байгуулан хог тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

ОНХС-ийн 1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгүүдийн урсгал засвар үйлчилгээг хийх ажлыг 1-р багийн Б. Отгонбаатартай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлж байна.

МЭДЭЭ ГАРГАСАН:

БОМЭРГЭЖИЛТЭН

Б. МӨНХЦЭЦЭГ